

АГУУЛГА

Бүлэг 1. Төслийн товч танилцуулга	4
2.2. Компанийн үйл ажиллагааны товч танилцуулга	6
2.2.1. Гэрээт нийлүүлэгчийн танилцуулга	6
2.2.2. Үндсэн хэрэглэгчид.....	7
2.2.3. Ажиллах боловсон хүчин	8
2.2.4. Дэд бүтцийн байгууламж, төлөвлөлтийн шийдэл	8
2.3. Агуулахад хадгалах бүтээгдэхүүний танилцуулга, нэр төрөл, тоо хэмжээ химийн нэгдэл агуулсан	9
2.3.1. Бүтээгдэхүүний танилцуулга	9
2.3.2. Импортлох бодисын нэр төрөл, хэмжээ	9
2.3.3.Химийн бодисын тээвэрлэлт	11
2.3.4.Хог хаягдал.....	12
2.3.5. Химийн бодисын тээвэрлэлт	14
2.4. Химийн бодисын агуулах, хадгалалтын нөхцөл	15
2.4.1. Химийн бодисын агуулах, хүчин чадал	15
2.4.2. Химийн бодисын агуулахын дүгнэлт	18
Бүлэг 2. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга	19
Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, буруулах арга зам	20
Бүлэг 3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт .	22
3.1 Төслөөс агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл	22
3.2. Төслөөс усны чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	24
3.3. Төслөөс хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл	26
3.4. Төслөөс ургамалан нөмрөгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл	27
3.5. Хүний эрүүл мэндэд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ	29
Бүлэг 4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт	31
Бүлэг 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	32

БҮЛЭГ 6. Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ	36
Бүлэг 7. Орчны тохижилт ногоон байгууламжийн арга хэмжээ	37
Бүлэг 7. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	38
Бүлэг 8. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	39
Бүлэг 9. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	41
Бүлэг 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	43
Байгаль орчны менежментийн 2026 оны төлөвлөгөөний нэгдсэн төсөв, дүгнэлт.....	46

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Талбайн байршлын координат	5
Хүснэгт 2. Химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүнийг импортлох, агуулахад хадгалах, худалдаалах бодисын жагсаалт	9
Хүснэгт 3. Химийн бодисын хуванцар сав, боодлын жилд гарах хэмжээ	13
Хүснэгт 4. Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл	14
Хүснэгт 5. Агаарын чанарт нөлөөлөх байдлын үнэлгээ.....	22
Хүснэгт 6. Усны нөөц, чанарт нөлөөлөх байдлын үнэлгээ	24
Хүснэгт 7. Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх нөлөөлөл	26
Хүснэгт 8. Ургамалжилтын зүйлийн бүрэлдэхүүн,.....	28
Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	32
Хүснэгт 10. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	36
Хүснэгт 11. Ногоон байгууламж төлөвлөлтийн зардал.....	38
Хүснэгт 12. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	39
Хүснэгт 13. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	41
Хүснэгт 14. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	44
Хүснэгт 15. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт	46

Зургийн жагсаалт

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил	6
Зураг 2. Харилцагч байгууллагууд	8
Зураг 3. Дроны өндрийн зураг	15
Зураг 4. Агуулахын доторх харагдах байдал	16
Зураг 5. Агуулахын ерөнхий байдал	16
Зураг 6. Агуулахын гадна талбайг бетонон хучилттай болгосон байдал.....	17
Зураг 7. Агуулахын гадна талбайг тойруулан бетонон хашлага хийсэн байдал.....	17

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: "Майнс АП" ХХК

Төсөл хэрэгжүүлэгчийн регистрийн дугаар: 5325153

Төслийн нэр: Химийн бодисын агуулах, тос, тосолгооны материал импортлох, хадгалах, худалдаалах төсөл

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Улаанбаатар 17011, Хан Уул-15, Дөрвөн улирлын цэцэрлэг, Моннис бюлдинг, 5-р давхар, "Майнс Ап" ХХК

Холбоо барих утас: 99110097, 99077308, 11320271

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил: Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэр, ДЦС IV-ын хойд талд байрлах "Эрчим Концерн"-ийн түрээсийн байранд хэрэгжинэ.

Төслийн хүчин чадал, товч тодорхойлолт

Тус компани нь франц, Сингапур улсаас нэр бүхий 22 төрлийн сав баглаа боодол бүхий 12 төрлийн химийн бодис агуулсан 17 төрлийн бараа бүтээгдэхүүнийг жилд дунджаар 797.6 тн-ыг импортлон зориулалтын агуулахад хадгалах ба гэрээлэгч байгууллагад хуваарийн дагуу худалдаална. Тус байгууллагын нийлүүлж буй бүтээгдэхүүний ихэнх хэсэг нь уул уурхайн тоног төхөөрөмжид ашиглагддаг тул үндсэн харилцагчид нь Монгол Улсад тэргүүлэгч "Оюу Толгой" ХХК, "Тийсс Монгол" ХХК, "Саусгоби Сэндс" ХХК, "Моннис Майнинг Эквипмент" ХХК, "ТТ Жэй Ви Си Өү" ХХК, Эрдэнэт үйлдвэр, МАК зэрэг уул уурхайн томоохон төслүүд байдаг.

Химийн бодисын агуулахын байр нь бетонон ханатай 1 давхар байр бөгөөд зоорьгүй, газардуулга, аялга зайлуулагчтай, байгалийн гэрэлтүүлэгтэй, агаар сэлгэх механик системтэй, бохир, цэвэр ус, дулаан төвийн шугамд холбогдсон, бетонон хашаатай, 24 цагийн харуул хамгаалалттай.

Химийн бодисын агуулах нь нийт 3200 м² талбайтай, 2700 м² гадна задгай талбайтай, 800 м² ISO танкны талбайтай бөгөөд хүн ам бага суурьшсан хороолол, усан сан бүхий газар, үер, усны аманд байрлаагүй, зэргэлдээх барилга байгууламжаас 500 м зайтай хийгдсэн.

Химийн бодисын агуулах нь нийт дотор болон гадна 6700 м² талбайтай, нэг дор 20000 тн химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүн хадгалах багтаамжтай ба хадгалж буй химийн бодисыг худалдаалах, сэлгэх хүчин чадлаар тооцвол жилд 150000 тн бодис хадгалах хүчин чадалтай. Агуулахад үндсэн ажилтнаар 7 хүн тогтмол ажиллана.

Химийн бодисын агуулах нь үерийн усны далан суваг шуудуутай, автомат агааржуулалтын 4 системтэй, анхны тусламжийн хайрцаг, нүд угаах шингэн байрлуулсан "Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг. MNS 5029:2011"-д заасан анхааруулах тэмдэг, дохио үг, аюулын тэмдэглэгээг агуулахын гадна болон дотор байрлуулсан.

"Майнс Ап" ХХК-ийн химийн бодис хадгалах агуулахын байр нь Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчийн дүгнэлтээр "Химийн хорт болон аюултай бодисын тухай" хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн заалт, "Хөдөлмөрийн эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын

бүтээгдэхүүний агуулах ерөнхий шаардлага" MNS 6458:2014 стандартын шаардлагыг хангаж байна хэмээн дүгнэсэн.

Газар ашиглах, эзэмших шийдвэр: Нийслэлийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 22-ний өдрийн А/571 тоот захирамж

Газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар: 0232749

Талбайн хэмжээ /м²/: 58714 м²

Хүснэгт 1. Талбайн байршлын координат

№	X	Y
1	5308692.61	634254.62
2	5308701.71	634266.32
3	5308707.94	634480.6
4	5308683.02	634482.62
5	5308684.05	634504.18
6	5308459.08	634525.26
7	5308472.78	634334.06
8	5308469.06	634333.39
9	5308466.61	634278.44

Тус компанийн үйл ажиллагаа явуулах объект нь "Эрчим концерн" ХХК-ийн эзэмшилд байдаг бөгөөд Аж ахуйн нэгж байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ /№ 0232749 тоот/-г Баянгол дүүргийн Засаг даргын 2012 оны 1 дүгээр сарын 02-ны өдрийн А/38 тоот шийдвэрийг үндэслэн, нэгж талбарын 168023/0057 дугаар бүхий 58714 м² талбайг 2012 оны 2 дугаар сарын 03-ны өдөр авсан байна Аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших гэрчилгээний хуулбарыг хавсаргав/.

Тус компанийн үйл ажиллагаа явуулах объект нь "Эрчим концерн" ХХК-ийн эзэмшилд байдаг бөгөөд Аж ахуйн нэгж байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ /№ 0232749 тоот/-г Баянгол дүүргийн Засаг даргын 2012 оны 1 дүгээр сарын 02-ны өдрийн А/38 тоот шийдвэрийг үндэслэн, нэгж талбарын 168023/0057 дугаар бүхий 58714 м² талбайг 2012 оны 2 дугаар сарын 03-ны өдөр авсан байна Аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших гэрчилгээний хуулбарыг хавсаргав/.

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил



2.2. Компанийн үйл ажиллагааны товч танилцуулга

"Майнс Ап" ХХК нь "Моннис" групп компанийн салбар компани бөгөөд уул уурхай, барилга, дэд бүтцийн томоохон төслүүдтэй хамтран ажиллаж, тэдгээрт дэвшилтэт технологи, техник тоног төхөөрөмжийг нийлүүлэн ажиллах чиглэлээр 2009 онд байгуулагдсан. Байгуулагдсан цагаасаа эхлэн дэлхийд чанараараа тэргүүлдэг АНУ-ын Goodyear брэндийн туузан дамжуулагч, Xylem брэндийн усны насос, Total брэндийн тос, тосолгооны материал, Clemcorp Australia брэндийн гүний уурхайн агааржуулалтын сэнс, Schindler брэндийн цахилгаан шат болон урсдаг шат, Okamura брэндийн тавилга зэрэг бүтээгдэхүүнийг Монгол Улсын зах зээлд албан ёсоор нийлүүлдэг байна.

2.2.1. Гэрээт нийлүүлэгчийн танилцуулга

Тус компани нь Монгол Улсад албан ёсны дистрибьюторын эрхтэйгээр Францын Total брэндтэй хамтран ажилладаг. Энэхүү брэнд нь дэлхийд газрын тос ба эрчим хүчний салбарын 6 тэргүүлэгч корпорацийн нэг бөгөөд Ази Номхон Далайн бүсэд уул уурхай, үйлдвэрлэлийн салбарт зах зээлийн хэмжээгээрээ тэргүүлдэг. Мөн түүнчлэн, уг брэндийн тос, тосолгооны материал нь хорт хий бага ялгаруулах нано-технологийг /Low-SAPS/ бүтээгдэхүүндээ шингээсэн байдгаараа онцлог байдаг байна.



2.2.3. Ажиллах боловсон хүчин

"Майнс Ап" ХХК нь нийт 21 ажилтантай бөгөөд тэдгээрээс агуулахын төсөлд 7 ажилтан ажилладаг. Үүнд:

1. Ханган нийлүүлэлтийн менежер – 1
2. Ложистик, үйл ажиллагааны менежер – 1
3. Төлөвлөгч 1
4. Гаалийн баталгаат агуулахын ажилтан – 2
5. Агуулахын ажилтан – 1
6. Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн 1 тус тус байна.

2.2.4. Дэд бүтцийн байгууламж, төлөвлөлтийн шийдэл

Зам холбоо, дэд бүтэц. Төслийн талбай нь Улаанбаатар хотын үйлдвэрийн баруун бүсэд ДЦТС-4 хойд талд дэд бүтэц сайн хөгжсөн, хатуу хучилттай замаар холбогдсон газар оршдог. Төслийн талбайд Дулааны цахилгаан станцын суурин тоног төхөөрөмжийг засварлах, сэргээх үйлчилгээг хийдэг байсан хуучин үйлдвэр байршдаг. Цахилгаан хангамж. Төслийн байгууламжийн цахилгаан хангамжийг ДЦТС-4 ТӨХК-н шугамаас шууд татан авдаг.

Усан хангамж ба дулаан хангамж. Төсөл хэрэгжүүлэх түрээсийн байгууламж нь дэд бүтцийн шугамд бүрэн холбогдсон тул төвийн дулааны сүлжээ, цэвэр усны хангамж болон төвлөрсөн ариутгах татуургын нэгдсэн шугам сүлжээнд холбогдсон.

Холбоо харилцаа. Төслийн талбай нь интернэт сүлжээ болон утасны шугам сүлжээнд холбогдсон тул Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бүх үүрэн телефон оператор компанийн сүлжээ ашиглах бүрэн боломжтой.

2.3. Агуулахад хадгалах бүтээгдэхүүний танилцуулга, нэр төрөл, тоо хэмжээ химийн нэгдэл агуулсан

2.3.1. Бүтээгдэхүүний танилцуулга

Тус компани нь өнөөдрийн байдлаар Монгол улсын зах зээлд 80 орчим төрлийн тос, тосолгооны материал нийлүүлж байгаа бөгөөд эдгээрээс уул уурхайн тоног төхөөрөмжид ашиглагдах нэр бүхий 22 төрлийн бүтээгдэхүүн нь “Химийн хортой буюу аюултай бодис”-ын ангилалд багтаж байна. Иймд эдгээр бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор химийн бодис хадгалахад зориулагдсан Монгол улсын “Химийн хорт болон аюултай бодисын тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн заалт “Хөдөлмөрийн эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын бүтээгдэхүүний агуулах ерөнхий шаардлага” MNS 6458:2014 стандарт болон бусад олон улсын стандартын шаардлагуудыг бүрэн хангасан агуулахад хадгалан уул уурхайн төслүүдэд нийлүүлнэ.

2.3.2. Импортлох бодисын нэр төрөл, хэмжээ

Химийн бодисын агуулах нь нийт 3200 м² талбайтай, 2700 м² гадна задгай талбайтай, 800 м² ISO танкны талбайтай бөгөөд хүн ам бага суурьшсан хороололд байрлаагүй, зэргэлдээх барилга байгууламжаас 500 м зайтай хийгдсэн.

Химийн бодисын агуулахад нэр бүхий 1 төрлийн химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүнийг хадгалах ба худалдаалах бөгөөд тэдгээр бодисын жагсаалт, Монгол болон олон улсын нэршил, химийн томъёо, CAS дугаар, жилд импортлох, худалдаалах хэмжээг дараах хүснэгтэд нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт 2. Химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүнийг импортлох, агуулахад хадгалах, худалдаалах бодисын жагсаалт

№	Монгол нэр	Олон улсын нэр	Импортлох улс, хилийн боомт	CAS дугаар	Зөвшөөрсөн хэмжээ, (тн)
1	Галын хор үүсгэгч шингэн	M2AFB005-5L M2AFB020-20L	Сингапур улс. Замын-Үүд	112-34-5 127-08-2	2000

Дээрх нэр бүхий 1 төрлийн химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүний химийн хорт болон аюултай бодисын эрсдэлийн үнэлгээг Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний түвшинд эрсдэлийн үнэлгээг нарийвчлан тооцох шаардлагатай

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗОРИУЛАЛТ, ДАВУУ ТАЛ

Muster

хөөсөн

суурьтай

систем:



Muster хөөсөн суурьтай гал унтраах систем нь нүүрс-устөрөгч суурьтай шингэн түлшнээс үүдэх галын өндөр эрсдэл агуулж буй эд хөрөнгийг хамгаалахад хамгийн тохиромжтой шийдэл юм. Ус дангаараа үр дүн багатай, эсвэл илүү их аюул дагуулах ч боломжтой. Харин хөөсийг нэмснээр усны гал унтраах үр дүнг хэд дахин нэмэгдүүлж, гадаргууг өргөнөөр бүрхэн, дуслуудыг

тоосруулан жижигрүүлж, хөргөх чадварыг нэмэгдүүлдэг. Уусмал дахь хөөсний үүрэг нь бүрхүүл үүсгэн, ууршилтыг хучиж, дахин гал авалцах боломжийг эсэргүүцэх юм.

Muster

импульс

нунтаг

систем:



Muster Impulse Powder System (IPS) бол өөрөө ялгаруулагч гал унтраах төхөөрөмж бөгөөд дотроо тусгай хуурай химийн нунтаг агуулдаг. Цахилгаан эсвэл дулаанаар өдөөгдсөн үедээ хий ялгаруулж, үр дүнд нь танк доторх даралтыг нэмэгдүүлдэг. Үүссэн даралт нь нунтгийг шингэн болгодог ба тодорхой нэг даралтад хүрсний дараа мембраныг задалж, нунтгийг танкнаас цацдаг. IPS танкнууд нь янз бүрийн хэмжээтэй байх бөгөөд аюултай хэсэгт суурилагддаг.

шууд

Үүнээс гадна нунтгийг урьдчилан загварчилсан хоолойн холболтоор дамжуулан, аюултай гэж тодорхойлсон газрууд руу шууд цацаж болно. Нунтгийн гал унтраах үйлчилгээ нь галын бүсэд нунтаг-хийн үүл үүсгэж галыг дардаг бөгөөд шатаж буй материалын гадаргуу дээр хөнжил үүсгэдэг.

Их иохилтоор нунтаг ялгаруулан маш хурдан унтраадаг. Өөрөө ялгаруулагч даралтгүй танктай Шаардлагатай хэсэгт ашиглаж болно. Чичиргээ, зэврэлт, чийгэнд тэсвэртэй. 7-10 жил ашиглагдах боломжтой.

Muster хатуу ялгаруулагч систем:

Muster Solid Aerosol Generators (SAG) систем нь өөрөө ялгаруулагч гал унтраах төхөөрөмж бөгөөд дотроо онигой бүхэл хатуу биет төлөвтэй химийн бодисыг агуулдаг. Цахилгаанаар эсвэл дулаанаар өдөөгдөх үедээ MUSTER MUST HUNTER микроны хэмжээтэй хэсгүүд болон хийнүүдийг ялгаруулдаг. Эдгээр элементүүд холилдож, нэгэн ижил шинж чанартай аэросолыг үүсгэн, гал унтраах бодис болдог ба галын химийн урвалын гинжин хэлхээг тасалдаг.

Бүтээгдэхүүний давуу тал:

- ✓ Хаалттай, далд орон зайд өөрөө ялгаруулагч аэросолыг хэрэглэдэг.
- ✓ Хүрээлэн буй орчинд хор нөлөөгүй.
- ✓ Хугацаа алдахгүй, огиом унтраах баталгаа олгодог.
- ✓ 7-10 жил ашиглах боломжтой.

2.3.3.Химийн бодисын тээвэрлэлт

"Майнс Ап" ХХК нь экспортлогч гадаадын компаниудтай гэрээ хийн, худалдан авахаар тохиролцон химийн бодисыг зохих журмын дагуу Монгол-Оросын хилийн Хиагт - Алтанбулаг, Монгол-Хятадын Замын-Үүдийн хилийн боомтоор төмөр замаар контейнер, вагоноор тээвэрлэн оруулж ирэх ба ачааны автомашинаар Улаанбаатар хотод орших Химийн бодисын агуулахад тээвэрлэн ирэхээр төлөвлөсөн байна.

Экспортлогч байгууллагаас "Майнс АП" ХХК нь нэр бүхий 1 төрлийн химийн бодис, бүтээгдэхүүнийг Химийн хортой болон аюултай бодисын тухай хууль, Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам батлах тухай БОАЖС, МУШС, ЭМС-ын хамтарсан 2017 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 54/А/136/А/215 тоот тушаал, түүнд заагдсан аюулгүй ажиллагааны зааварчилгаа, аюул, ослын үед ажиллах төлөвлөгөө, химийн хорт болон аюултай бодис тээвэрлэхэд тавих үндсэн болон нэмэлт шаардлагын дагуу Улаанбаатар хотын Баянгол дүүргийн нутагт байрлах Химийн бодисын агуулахад тээвэрлэн авчирч хадгалах ба гэрээлэгч байгууллагад хуваарийн дагуу нийлүүлнэ. Тээвэрлэлтийг 7 хоногт дунджаар 1-2 удаа тогтсон маршрутын дагуу тээвэрлэнэ.

Химийн бодисууд болон химийн бүтээгдэхүүнүүдийн сав хайрцгийн овор хэмжээ, хаяглалт, холбогдох мэдээллүүд нь олон улсын стандарт, импортлогч болон хэрэглэгч үйлдвэрүүдийн технологийн дагуу хийгдсэн тохиолдолд хэвийн нөхцөлд тээвэрлэх болон шилжүүлэн ачих, хэрэглэхэд харшлах зүйлгүй гэж үздэг.

2.3.4.Хог хаягдал

Хатуу хог хаягдал. Тус байгууллага нь Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20-р хорооны "Эрчим концерн"-ийн Химийн бодисын агуулахад Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчийн "Химийн бодисын агуулахын тухай" дүгнэлтийг тус гаргуулсан бөгөөд уг дүгнэлтээр стандартын шаардлага хангасан барилга байгууламж тул шинээр нэмж барилга байгууламж барихгүй, барилгын ажил явагдахгүй тул үйл ажиллагаанаас барилгын хог хаягдал гарахгүй. Мөн төсөл хэрэгжих түрээсийн байгууламж нь барилгын төвлөрсөн ариутгах татуургын системийн дамжуулах, түгээх зориулалт бүхий инженерийн байгууламжийн угсралтын ажлыг стандартын дагуу хийж гүйцэтгэсэн, Улаанбаатар хотын дэд бүтцийн шугам, төвийн дулааны сүлжээ, цэвэр усны хангамж болон төвлөрсөн ариутгах татуургын нэгдсэн шугам сүлжээнд холбогдсон тул ахуйн хаягдал гарахгүй болно.

Ахуйн хог хаягдал. Ажилчид, ахуйн хэрэглээнээс гарч байгаа бүх төрлийн хаягдал хамаарна. Нэг хүн өдөрт дунджаар 0.3 кг хог хаягдал гаргадаг гэж тооцоонд тусгав. Үйл ажиллагааны явцад ахуйн хуурай хог хаягдал сард дунджаар 0.063 тн, жилд дунджаар 0.76 тн энгийн хатуу хог хаягдал гарах бөгөөд ахуйн хог хаягдлыг тусгайлан зассан хог хаягдал түр хадгалах цэгт цуглуулан сард 1 удаа Баянгол дүүргийн ТҮК-тэй гэрээ байгуулан зайлуулна.

Химийн бодисын сав баглаа боодлын хаягдал.



Химийн бодисын агуулахад хадгалан худалдаалахаар төлөвлөсөн нэр бүхий 1 төрлийн химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүнийг химийн бодисын агуулахад тээвэрлэн авчирч хадгалах ба тодорхой хуваарийн дагуу өөрсдийн бүтээгдэхүүн борлуулах цэг болон гэрээлэгч байгууллагуудад худалдаалахаар төлөвлөсөн.

Харин худалдаалахаар төлөвлөсөн нэр бүхий 1 төрлийн бүтээгдэхүүнээс 25 тн-ын багтаамжтай хуванцар сав, гарах бөгөөд дараах хүснэгтэд дэлгэрэнгүй үзүүлэв.

Хүснэгт 3. Химийн бодисын хуванцар сав, боодлын жилд гарах хэмжээ

№	Бодисын Монгол нэр	Химийн бодисын төлөв	Хэмжин Нэгж	Савлагааны төрөл, хэмжээ	Жилд импортлох хэмжээ/тн/	Тоо гарах хэмжээ /ш/
1.	Галын хор үүсгэгч шингэн	M2AFB005-5L M2AFB020-20L	литр	Хуванцар сав, 20 литр	2000	100000
Нийт		Хуванцар сав /25 литр/				100000

Худалдаалахаар төлөвлөсөн нэр бүхий 1 төрлийн химийн бодис-бүтээгдэхүүний сав баглаа боодлоос жилд дунджаар 25 кг-ын багтаамжтай хуванцар сав 100000 ш хаягдал гарна. Тус үйлдвэрээс гарч буй сав баглаа боодлын хаягдал нь "Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл батлах тухай" Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/349 тоот тушаалын хавсралтад зааснаар Сав баглаа боодлын хаягдал бүлгийн "Хортой бодисын үлдэгдэл агуулсан эсвэл бохирдсон сав баглаа боодол" хэсэгт /хог хаягдлын төрлийн код - 15 01 09*/ заасны дагуу аюултай зэрэглэлд хамаарч байна.

Хүснэгт 4. Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл

Бүлгийн код	Хог хаягдлын бүлэг	Дэд бүлгийн код	Хог хаягдлын дэд бүлэг	Хог хаягдлын төрлийн код	Хог хаягдлын төрөл	Аюулын зэрэглэл
15	Сав баглаа боодлын хаягдал: Шингээгч, бохир алчуур материал, фильтрийн материал, тусгайлан заагдаагүй хамгаалалтын хувцас	15 01	Сав баглаа боодол (ангилаан ялгасан ахуйн сав баглаа боодлын хаягдал орно)	15 01 09*	Хортой бодисын үлдэгдэл агуулсан эсвэл бохирдсон сав баглаа боодол	А

Тус компани нь аюултай хог хаягдлыг Хог хаягдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-д заасны дагуу аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй “Түмэн Эгшиг” ХХК-тай “Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээ”-г байгуулан ажиллаж байна /

2.3.5. Химийн бодисын тээвэрлэлт

“Майнс Ап” ХХК нь экспортлогч гадаадын компаниудтай гэрээ хийн, худалдан авахаар тохиролцон химийн бодисыг зохих журмын дагуу Монгол-Оросын хилийн Хиагт - Алтанбулаг, Монгол-Хятадын Замын-Үүдийн хилийн боомтоор төмөр замаар контейнер, вагоноор тээвэрлэн оруулж ирэх ба ачааны автомашинаар Улаанбаатар хотод орших Химийн бодисын агуулахад тээвэрлэн ирэхээр төлөвлөсөн байна.

Химийн бодисууд болон химийн бүтээгдэхүүнүүдийн сав хайрцгийн овор хэмжээ, хаяглалт, холбогдох мэдээллүүд нь олон улсын стандарт, импортлогч болон хэрэглэгч үйлдвэрүүдийн технологийн дагуу хийгдсэн тохиолдолд хэвийн нөхцөлд тээвэрлэх болон шилжүүлэн ачих, хэрэглэхэд харшлах зүйлгүй гэж үздэг.

2.4. Химийн бодисын агуулах, хадгалалтын нөхцөл

2.4.1. Химийн бодисын агуулах, хүчин чадал

"Майнс Ап" ХХК нь “Эрчим Концерн”-ийн түрээсийн байранд химийн бодисын агуулах байгуулан ажиллаж байгаа бөгөөд уг байгууламж нь 90 м² бетонон ханатай, зоорьгүй, газардуулга, аянга зайлуулагчтай, байгалийн гэрэлтүүлэгчтэй, агаар сэлгэх механик системтэй, бохир болон цэвэр ус, дулаан хангамжийн төвийн шугамд холбогдсон, бетонон хашаатай, 24 цагийн харуул хамгаалалт бүхий 1 давхар байгууламж юм.

Зураг 3. Дроны өндрийн зураг



Тус агуулах нь ан цав хотгор гүдгэргүй цементэн шалтай, ус тогтохгүй зэвэрдэггүй будгаар будсан налуу дээвэртэй, агуулахын хана нь химийн бодисоос үүссэн тоос, уур манан тогтохооргүй гөлгөр гадаргуутай, гадна талдаа хаалга болон орчныг тусгасан прожуктор гэрэлтүүлэгтэй, галын хуурай хороор тоноглогдсон, аваарын 2 гарцтай, барилга байгууламж нь мэргэжлийн байгууллагаар хийгдсэн газардуулгын системтэй.

Зураг 4. Агуулахын доторх харагдах байдал



Автомат агааржуулалтын 4 системтэй, анхны тусламжийн хайрцаг, нүд угаах шингэн байрлуулсан “Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг. MNS 5029:2011 ”-д заасан анхааруулах тэмдэг, дохио үг, аюулын тэмдэглэгээг агуулахын гадна болон дотор байрлуулсан.

Зураг 5. Агуулахын ерөнхий байдал



Агуулах нь үерийн усны далан суваг шуудуу бөгөөд тос тосолгооны материал, бүтээгдэхүүн алдагдахаас сэргийлэн агуулахын хашааг бүрэн бетондсон, агуулахын байрыг тойруулан 30 см өндөр бетонон хамгаалалт хийсэн байна.

Зураг 6. Агуулахын гадна талбайг бетонон хучилттай болгосон байдал



Зураг 7. Агуулахын гадна талбайг тойруулан бетонон хашлага хийсэн байдал



Химийн бодисын агуулах нь нийт 3200 м² талбайтай, 2700 м² гадна задгай талбайтай, 800 м² ISO танкны талбайтай бөгөөд хүн ам бага суурьшсан хороолол, усан сан бүхий газар, үер, усны аманд байрлаагүй, зэргэлдээх барилга байгууламжаас 500 м зайтай хийгдсэн. Химийн бодисын агуулах нь нийт дотор болон гадна 6700 м² талбайтай, нэг дор 20000 тн химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүн хадгалах багтаамжтай ба хадгалж буй химийн бодисыг худалдаалах, сэлгэх хүчин чадлаар тооцвол жилд 150000 тн бодис хадгалах хүчин чадалтай. Агуулахад үндсэн ажилтнаар 7 хүн тогтмол ажиллана.

2.4.2. Химийн бодисын агуулахын дүгнэлт

Тус байгууллага нь Химийн бодисын агуулахад “Химийн бодисын агуулахын тухай” Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчийн 2018 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 02-04-190/173 тоот дүгнэлтийг гаргуулсан байна /Химийн бодисын агуулахын дүгнэлтийн хуулбарыг хавсаргав/.

Тус дүгнэлтэд: Тус газарт ирүүлсэн Баянгол дүүргийн 20 дугаар хороо ДЦТС-4 хойд талд байрлах “Эрчим концерн”-ийн түрээсийн байранд химийн бодис агуулахын дүгнэлт гаргуулах хүсэлтээр МХЕГ-ын даргын баталсан “Баталгаажуулалтын хяналт шалгалт хийх тухай” 01/51 тоот удирдамжаар 2018 оны 2 сарын 26-ны өдөр менежер Б.Идэр, Н.Энхбаяр нарыг байлцуулан Байгаль орчны хяналтын улсын байцаагч Г.Удвал, Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч Б.Мөнхбат нар хяналт шалгалт хийжээ.

Хяналт шалгалтаар: “Майнс Ап” ХХК нь гадаад дотоод худалдаа эрхлэх аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн 9011207098 тоот гэрчилгээтэй /регистр 5325153/. Тус компани нь франц, Сингапур улсаас 22 сав баглаа боодол бүхий 17 нэр төрлийн бодис уул уурхайн тоног төхөөрөмжид ашиглагдах антифриз, шээгний уусмал импортлох МП-2014-043 тоот гэрээтэй, тухайн бодисын хор аюулын лавлах мэдээллийн хуудастай. Химийн бодисын агуулахын байр нь 90 м² бетонон ханатай 1 давхар байр, зоорьгүй, газардуулга, аянга зайлуулагчтай, байгалийн гэрэлтүүлэгтэй, агаар сэлгэх механик системтэй, бохир, цэвэр ус, дулаан төвийн шугаманд холбогдсон, бетонон хашаатай, 24 цагийн харуул хамгаалалттай. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний “Алтан эхлэл” ХХК-аар төслийг хийлгэсэн 2017 оны тайлантай. Агуулахын ажлын байранд Баянмонгол дүүргийн онцгой байдлын газраас онд олгосон Д/103/348 тоот галын аюулгүй байдлын дүгнэлттэй. Агуулахын байранд хийсэн физик хэмжилтээр байгалын гэрэлтүүлэг 220 люкс байна. Ажилтанд ажлын хувцас хамгаалах, хэрэгслийг олгосон байна.

Дээрх байдлыг үндэслэн дүгнэлт болгох нь. “Майнс Ап” ХХК-ийн химийн бодис хадгалах агуулахын байр нь: “Химийн хорт болон аюултай бодисын тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн заалт, “Хөдөлмөрийн эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын бүтээгдэхүүний агуулах ерөнхий шаардлага” MNS 6458:2014 стандартын шаардлагыг хангаж байна хэмээн дүгнэжээ.

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн физик газарзүй ба эдийн засгийн хөгжил

Цаг уур амьсгал: Улаанбаатар хот орчим нь уур амьсгалын хуурайдуу сэрүүвтэр мужийн нэн хүйтэн дэд мужид хамрагдана. Уур амьсгалын үндсэн нөхцөл байдал нь эх газрын эрс тэс уур амьсгалаар тодорхойлогдоно. Агаарын олон жилийн дундаж температур -1.2°C хамгийн хүйтэн 1 дүгээр сард -39.6°C , хамгийн дулаан нь 7 дугаар сард $+34.5^{\circ}\text{C}$, байдаг бөгөөд агаарын температурын агууриг 74.1°C байдаг. Улаанбаатар хотын бүсэд салхи ихэвчлэн хойд баруун хойноосоо чиглэлтэй, салхины жилийн хурд 2.2 м/сек байдаг. Хур хэмжээ олон дунджаас үзэхэд 258.5 мм бөгөөд 90% нь дулааны улиралд буюу 4-9 дүгээр саруудад ордог. Өвлийн улиралд хур тунадас багатай. Тогтвортой цасан бүрхэвч 11 дүгээр сараас 3 дугаар сарын сүүлч үе хүртэл үргэлжилнэ.

Газрын гадарга: Хэнтийн нурууны баруун урд үзүүрт хамаарагдах Толгойт (1831.5 м) уулын зүүн үзүүрт байрлана. Талбай байрлах хэсэг нь Туул голын цутгал, хөндийн системд хамаарах ба техноген үйл ажиллагааны үр дүнд газрын хэлбэр дүрс бүрэн өөрчлөгдөж хүний үйл ажиллагаатай холбоотой бохирдлын далан, инженерийн барилга байгууламжууд, тэдгээрийн хооронд холбосон зам, явган хүний замуудын нөлөөгөөр тэгш байдалтай болсон байна.

Гадаргын болон гүний ус: Хотын нутаг дэвсгэрийн усан сүлжээг Туул, Сэлбэ, Улиастай, Толгойт голууд тэдгээрийн салбар гол горхиуд бүрдүүлдэг. Туул голын голдирлын өргөн Улаанбаатар хотын орчимд 44-55 м, хуурай жилүүдэд 5-18 м байдаг. Гантай гачиг үед голын усны түвшин 0.9-1.2 м байдаг бол үерлэлтийн үедээ голын усны түвшин 1.2-2.0 м-ээр дээшилдэг. Улаанбаатар хотын нутаг дэвсгэр болон төслийн талбайгаас Туул гол нь 350 м зайд байрлаж байна. Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах гүний худгаас жилд 684 м³ ус ашигладаг байна.

Хөрсөн бүрхэвч: Төсөл хэрэгжих талбайн нэгж талбараас хөрсний зүсэлт хийж биологийн болон хүнд металлын бохирдлын дээж авлаа. Хөрсний механик бүрэлдэхүүний хувьд элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй. Хөрсний агрохимийн шинж чанарыг харахад урвалын орчин нь хүчтэй шүлтлэг шинжийг үзүүлэх бөгөөд ялзмагийн хангамж нь хангалттай, хялбар уусах давсны агууламж 0.193 dS/m хэмжээтэй байна. Хөрсөн дэх хүнд металлын агууламж нь шинжилгээний дүнгээс үзэхэд хөрсөн дэх кадми илрээгүй харин элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй хөрсөн дэх хүлцэх агууламжаас хром, хар тугалга, зэс, никель, цайрын агууламж MNS 5850:2019 стандарт хэмжээнээс давсан үзүүлэлт байхгүй байна.

Ургамлан нөмрөг: Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн ихэнх хэсэг нь ботаник-газарзүйн мужлалаар уулын ойт хээрийн Орхон – Сэлэнгийн дэд муж, хойт хэсэг нь Хэнтийн уулын тайгын мужид хамрагдана. Хотын нутаг дэвсгэрийн ихэнх хэсэгт Өмнөд- Сибирь-Монголын умардын хэв шинжийн уулын тайгархаг ойтой. Төслийн нөлөөнд орших Толгойтын голын хөндийд алаг өвс – улалж - үетэнт (*Geranium pretence*, *Sanguisorba officinalis*, *Agropyron repens*, *Carex duriuscula*) зэрэг нугархаг ургамалшил зонхилох боловч антропогени нөлөөллийн улмаас ургамал бүрхэвч устан алга болсон байна.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, буруулах арга зам

Химийн бодисуудын хадгалалт, тээвэрлэлтийн үед цаг агаарын болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэхийн тулд хадгалж буй агуулах нь доор дурдсан шаардлагуудыг хангасан байх ёстой. Үүнд:

1. Химийн бодисын агуулахын агааржуулалтын системийн ажиллагаа, агааржуулалтын хоолойн бүрэн бүтэн байдал, химийн бодисын савны болон асгарсан бодис тарахаас сэргийлсэн тосгуур, суурины зузаан, идэгдэлт, химийн бодис тавьсан тавиур болон холбоосны механик бүрэн бүтэн байдал, тавиур дээр хадгалж буй бодисын дээд хэмжээг байнгын хяналт тавихаас гадна шатамхай, онцгой хортой бодисын сав баглаа боодлыг өдөрт 1 удаа, бусад бодисыг долоо хоногт 1 удаа шалгаж хяналтыг тогтмол хугацааны давтамжтайгаар хийж, тэмдэглэл хөтөлж байх.
2. Химийн бодисын агуулахын ажлын байр нь галд тэсвэржилтийн зэргийг хангахуйц материал, хийцтэй, болзошгүй ослын үед хөрсөнд болон гадагш бодис алдагдахааргүй шал (цементэн болон плитан), бат бэх хамгаалалт бүхий цонх, хаалгатай байхаар засаж тохижуулах.
3. Химийн бодисын агуулахад хор аюулын лавлах мэдээлэлд тусгасны дагуу хоорондоо нийцэхгүй бодисуудыг хамт хадгалахгүй байх.
4. Бүх химийн бодисыг халаалтын хэрэгсэл, цахилгааны эх үүсвэр, системээс хол, шууд нарны гэрэл тусахааргүй нөхцөлд хадгалах зэрэг болно.

Агаарын чанар

1. Химийн бодисын агуулахын ажиллагсад бодистой ажиллах болон асгарсан бодисыг саармагжуулах, хурааж авах зэрэг ажиллагааны явцад хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэлгүй ажиллах зэрэг тохиолдолд бодист түлэгдэх, бодисын уураар амьсгалах, хордох зэрэг эрсдэл үүсэж болзошгүй тул хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг сайтар ханган ажиллах.
2. Химийн хортой болон аюултай бодисын хадгалалтын болон хадгалах хугацааны горимыг нарийн чанд баримтлах, ялангуяа тодорхой хугацааны дараа уурших, задрах гэх мэтээр бүтэц найрлага нь өөрчлөгддөг тогтвортой биш бодис болон савлагааны материал нь хязгаарлагдмал ашиглалтын хугацаатай химийн бодисыг агуулахад хадгалахад үйлдвэрлэгчээс зааж өгсөн хугацааг хянаж, хуучин бодисыг эхэлж худалдаалах зарчмыг баримтлах.
3. Химийн бодисыг шатах, гал авалцах эх үүсвэр болон хамт хадгалж болохгүй бодисуудыг тусад нь хадгалах.
4. Химийн бодисын агуулахын хадгалах нөхцөлийг стандартын шаардлагын түвшинд тохижуулах, хор аюулын лавлах мэдээлэлд тусгагдсан зааврын дагуу хадгалах, ялангуяа химийн бодисын агуулахад хор аюулын лавлах мэдээлэлд тусгагдсаны дагуу хоорондоо нийцэхгүй бодисуудыг хамт хадгалахгүй байх.
5. Химийн бодисын агуулахад шатах, гал авалцах эх үүсвэр болон шатамхай, тэсэрч дэлбэрэх эрсдэлтэй бодис, бүтээгдэхүүнийг нэг дотор хадгалахгүй байх зэрэг болно. Агаарын чанар, дуу шуугианы хяналт шинжилгээг тогтмол хийх, ОХШ-ний тэмдэглэл хөтөлж, зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн, анхаарах аюултай тохиолдол бүрийг судалж шаардлагатай хариу арга хэмжээг авч ажиллана.

Хөрсөн бүрхэвч

1. Химийн бодисын агуулахын барилга байгууламж нь шалыг химийн үйлчлэлд тэсвэртэй зузаан материалаар хийсэн боловч нэвчилт, алдагдлыг байнга шалгаж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч байх.
2. Тээвэрлэлт, хадгалалтын үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулах, химийн бодисыг хөрсөнд алдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг байнга авч хэрэгжүүлэх
3. Химийн бодисын агуулахын ажлын байр нь тухайн бодисын хор аюулын лавлах мэдээлэлд заасан шингээгч материалаар (зориулалтын шингээгч, хуурай элс тогтворжуулагч, үртэс гэх мэт) хангагдсан байна. Химийн бодис асгарах, алдагдах үед ашиглах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хоосон сав, бортого, бортого онгойлгогч, наалддаг шошго, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэрэг багаж хэрэгслээр хангагдсан байх зэрэг болно.

Гадаргын болон газрын доорх ус

- 1.Химийн бодисын агуулахын барилга байгууламж нь шалыг химийн үйлчлэлд тэсвэртэй зузаан материалаар хийсэн боловч нэвчилт, алдагдлыг байнга шалгаж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч байх.
2. Зарим төрлийн химийн бодис нь усан орчинд богино хугацааны хурц хоруу чанартай, усны амьд организмд хортой зэрэглэлд хамаарах бодис тул химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтыг хор аюулын лавлах мэдээлэлд тусгасны дагуу явуулах, усан орчинд нөлөөлөл үзүүлэхээс урьдчилан сэргийлэх
3. Химийн бодисын агуулахад химийн бодис, бүтээгдэхүүнийг татан авчрах, хүлээн авах үйл ажиллагааг явуулахдаа хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах ажиллах зэрэг болно.

Ургамлан нөмрөг

- 1.Химийн бодисын аюулгүй ажиллагаа, түүнийг зөрчсөнтэй холбоотой осол аваар нь голдуу техник, технологийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааны горим алдагдсанаас үүдэлтэй байдаг. Химийн хортой болон аюултай бодисыг тээвэрлэх болон устгах үеийн аюулгүй ажиллагаа зөрчигдсөнөөс болон ургамлан нөмрөг, ургамалжилтад үзүүлэх сөрөг нөлөөлөл илүү байна. Иймээс химийн бодис тээвэрлэх, хадгалах журамд заагдсаны дагуу алдаж асгахаас сэргийлэх арга хэмжээ авах хэрэгтэй.

Амьтны аймаг

1. Төслийн үйл ажиллагаа, осол аваарын үед техникийн гаралтай бохирдуулагч хөрсөнд нэвчиж, ургамалжилтад нөлөөлөл үзүүлэх, бохирдуулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ байнга авч байх шаардлагатай.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1 Төслөөс агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Химийн бодисын хадгалалт, тээвэрлэлтээс агаарын чанарт хэдэн хүчин зүйлсээр нөлөөлөл үзүүлж болзошгүй. Эдгээр нь химийн бодисын тээвэрлэлт, хадгалах үед гадаад орчны болон ажлын байрны агаарын чанар, найрлагыг өөрчилж болзошгүй байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

- 1.Химийн бодисын агуулахад химийн бодистой харьцан ажиллах үед санамсаргүй асгах, алдах, агуулахын шал, гадаад орчинд асгарснаас ажлын байрны орчны агаарт нөлөөлөх.
- 2.Химийн хорт болон аюултай бодис агуулж байгаа сав нь хэт удаан хадгалах, нарны гэрэл тусах, хөлдөх, халах, зэврэх, урвалд орох зэргээс эвдрэх, цоорох, зөөлрөх зэрэг гэмтлээс шалтгаалан асгарч алдагдах, ажлын байрны агаарт тархах.
- 3.Химийн хортой болон аюултай бодисыг гадна талбайд ил задгай хаяснаас агаарт тэсрэмтгий хольц үүсгэх, гадаад орчинд агаарын урсгалаар дамжин нөлөөлөх.
- 4.Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдсанаас ууршимтгай, дэгдэмхий бодисууд агаарт уурших, исэлдэн урвалдах зэргээр агаарын чанар найрлагад нөлөөлөх.
- 5.Химийн бодистой шатах, гал авалцах эх үүсвэрийг ойр байлгаснаар гал түймэр гарах, тэсэрч дэлбэрснээр хортой хий ялгаран агаарын чанар, хүний эрүүл мэндэд нөлөөлөх
- 6.Тухайн бодисыг хадгалах үед хор аюулын лавлах мэдээлэлд заасан хадгалах нөхцөлийг хангасан орчныг агуулахад бүрдүүлээгүйгээс агаарын найрлага өөрчлөгдөх, улмаар хүний эрүүл мэндэд нөлөөлөх зэрэг болно.

Төсөлд ашиглаж буй химийн бодисуудын хадгалалт, ашиглалтын явцад орчны агаарын чанарт үзүүлэх нөлөөллийн хэмжээг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 5. Агаарын чанарт нөлөөлөх байдлын үнэлгээ

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
1	Химийн бодисын агуулахад химийн бодистой харьцан ажиллах үед санамсаргүй асгах, алдах, агуулахын шал, гадаад орчинд асгарсанаас ажлын байрны орчны агаарт нөлөөлөх	Зайлшгүй					
		Боломжтой					
		Магадгүй		х			
		Магадлал муутай					
		Ховор					

2	Химийн хорт болон аюултай бодис агуулж байгаа сав нь хэт удаан хадгалах, нарны гэрэл тусах, хөлдөх, халах, зэврэх, урвалд орох зэргээс эвдрэх, цоорох, зөөлрөх зэрэг гэмтлээс шалтгаалан асгарч алдагдах, ажлын байрны агаарт тархах	Зайлшгүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
3	Химийн хортой болон аюултай бодисыг гадна талбайд ил задгай хаяснаас агаарт тэсрэмтгий хольц үүсгэх, гадаад орчинд агаарын урсгалаар дамжин нөлөөлөх	Зайлшгүй					
		Боломжтой					
		Магадгүй	х				
		Магадлал муутай					
		Ховор					
4	Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдсанаас ууршимтгай, дэгдэмхий бодисууд агаарт уурших, исэлдэн урвалдах зэргээр агаарын чанар найрлагад нөлөөлөх	Зайлшгүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
5	Химийн бодистой шатах, гал авалцах эх үүсвэрийг ойр байлгаснаар гал түймэр гарах,	Зайлшгүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
		Зайлшгүй					
		Боломжтой					

		Магадгүй				
		Магадлал муутай				
		Ховор	х			
			5	1	-	-
			83.3	16.6	-	-
	ДҮГНЭЛТ	Химийн бодисын хадгалалт, ашиглалтаас агаарын чанарт үзүүлэх нөлөөллийн эрчим, цар хүрээгээр 100 % бага, маш бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд тохиолдох магадлалаар авч үзвэл 66.6% нь ховор байна. Гэхдээ химийн бодисын агуулахад химийн бодистой харьцан ажиллах үед санамсаргүй асгах, алдах, агуулахын шал, гадаад орчинд асгарсанаас ажлын байрны орчны агаарт нөлөөлж болзошгүй тул нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн тохиолдолд сөрөг нөлөөлөөс урьдчилан сэргийлэх боломжтой.				

3.2. Төслөөс усны чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

“Майнс АП” ХХК-ийн Химийн бодисын агуулах нь зөвхөн хадгалалтын үйл ажиллагаа явуулах тул агуулахын ажлын байрны барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийг сайтар ханган ажиллах шаардлагатай.

Төслийн үйл ажиллагаанаас усны чанар, найрлагад химийн бодисуудын тээвэрлэлт, хадгалалтаас дараах төрлийн нөлөөллүүд үүсэж болзошгүй. Үүнд:

1. Химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдлоос үүдэн газрын гадаргад химийн бодис алдагдах, улмаар түүний урсцаар тархаж, голдирлын дагуух усыг бохирдуулах.
2. Усан орчинд богино хугацааны хурц хоруу чанартай, усны амьд организмд хортой зэрэглэлд хамаарах бодисын хадгалалт, ашиглалтыг зохих журмын дагуу явуулаагүйгээс усан орчинд нөлөөлөх
3. Тээвэрлэх, хүлээн авах үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс химийн бодисыг түр урсцын голдирлуудад асгах, талбайд татан ирэх явцад бохирдлын эх үүсвэрийг бий болгох зэрэг болно.

Химийн бодисын агуулахад хадгалж буй бодисуудаас усны чанар, найрлагад үзүүлэх нөлөөллийн хэмжээг доорх хүснэгтэд үзүүлэв

Хүснэгт 6. Усны нөөц, чанарт нөлөөлөх байдлын үнэлгээ

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн н эрчим, цар хүрээ	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
		Тохиолдох магадлал	Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
1	Химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдлоос үүдэн газрын гадаргад химийн бодис алдагдах, улмаар түүний урсцаар тархаж, голдрилын дагуух усыг бохирдуулах	Зайлшгүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
2	Усан орчинд богино хугацааны хурц хоруу чанартай, усны амьд организмд хортой зэрэглэлд хамаарах бодисын хадгалалт, ашиглалтыг зохих журмын дагуу явуулаагүйгээс усан орчинд нөлөөлөх	Зайлшгүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
3	Тээвэрлэх, хүлээн авах үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс химийн бодисыг түр урсцын голдрилуудад асгах, талбайд татан ирэх явцад бохирдлын эх үүсвэрийг бий болгох	Зайлшгүй					
		Боломжтой					
		Магадгүй		х			
		Магадлал муутай					
		Ховор					
	НИЙТ		2	1	-	-	-
	ЭЗЛЭХ ХУВЬ (%)		66.6	33.3	-	-	-

	ДҮГНЭЛТ	Химийн бодисын хадгалалт, ашиглалтаас усны чанар найрлагад үзүүлэх нөлөөлөл 100 % бага, маш бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд тохиолдох магадлалын 66.6% нь ховор тохиолдохоор байна. Тухайн төслийн хувьд анхаарах гол асуудал нь химийн бодисыг тээвэрлэх, хүлээн авах үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс химийн бодисыг түр урсцын голдрилуудад асгах, талбайд татан ирэх явцад бохирдлын эх үүсвэрийг бий болгох нөхцөлтэй байна. Тиймээс химийн бодисын тээвэрлэлт, нийлүүлэлт хийх үедээ татан авчрах, ачиж тээвэрлэх асуудлыг зохих журмын дагуу явуулсан тохиолдолд нөлөөлөл үзүүлэхгүй байх боломжтой байна.
--	---	---

3.3. Төслөөс хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Төслийн хэмжээнд хэрэглэгдэх химийн бодисуудаас хөрсний чанарт цөөн хэдэн хүчин зүйлсээр нөлөөлж болзошгүй. Химийн бодис нь газрын хөрсөнд стандартад заасан хэмжээнээс ихээр хуримлагдвал хөрсний ус ургамлаар дамжин нутгийн оршин суугчдын амьдрах орчин, хөрсний бичил биетэн, биосферт муугаар нөлөөлөх тул бодис тус бүрийг тээвэрлэх, хадгалах нөхцөлийг хангах шаардлага тавигдана.

Химийн бодисуудын тээвэрлэлт, хадгалалтаас үүсэж болзошгүй нөлөөллүүдийг доор үзүүлэв. Үүнд:

1. Химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдол, химийн бодисын хадгалалтын горим алдагдсанаар хөрсөнд их хэмжээгээр шингэх, хөрсөн бүрхэвчинд сөрөг нөлөөлөх.
2. Химийн бодис тээвэрлэх, хадгалах үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс химийн бодисыг хөрсөнд алдаж, түүний найрлага бүтцийг өөрчлөх
3. Хөрсөнд их хэмжээний химийн бодис алдагдсанаар ургамалжилт, хөрсний бичил биетэнд дам нөлөөлөл үзүүлэх зэрэг болно.

Хүснэгт 7. Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх нөлөөлөл

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
		Зайлшгүй					

1	Химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдол, химийн бодисын хадгалалтын горим алдагдсанаар хөрсөнд их хэмжээгээр шингэх, хөрсөн бүрхэвчинд сөрөг нөлөөлөх	Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
2	Химийн бодис тээвэрлэх, хадгалах үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс химийн бодисыг хөрсөнд алдаж, түүний найрлага бүтцийг өөрчлөх	Зайлшгүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
3	Хөрсөнд их хэмжээний химийн бодис алдагдсанаар ургамалжилт, хөрсний бичил биетэнд дам нөлөөлөл үзүүлэх	Зайлшгүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
	НИЙТ		3	-	-	-	-
	ЭЗЛЭХ ХУВЬ (%)		100	-	-	-	-
	ДҮГНЭЛТ	Химийн бодисын агуулах болон бодисын хадгалалт, тээвэрлэлтээс хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл 100% маш бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд дохиолдох магадлалаар нь авч үзвэл ховор тохиолдох магадлалд орж байна.					

3.4. Төслөөс ургамалан нөмрөгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Төсөл хэрэгжих орчны ургамлан нөмрөг химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтаас үүдэлтэй нөлөөлөлд автах, доройтох нь бага боловч зарим төрлийн осол аваар, техникийн аюулгүйн ажиллагааны алдаанаас шалтгаалан шууд болон дам сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй байна. Үүнд:

- 1.Тээвэрлэх болон агуулахад татан авчрах, хадгалалтын горим зөрчигдсөнөөр химийн бодис хөрсөнд нэвчиж, ургамалжилтад нөлөөлөл үзүүлэх, бохирдуулах
- 2.Осол аваарын үед техникийн гаралтай бохирдуулагч хөрсөнд нэвчиж, ургамалжилтад нөлөөлөл үзүүлэх, бохирдуулах зэрэг болно.

Хүснэгт 8. Ургамалжилтын зүйлийн бүрэлдэхүүн,

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн н эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюулга й
1	Тээвэрлэх болон агуулахад татан авчрах, хадгалалтын горим зөрчигдсөнөөр химийн бодис хөрсөнд нэвчиж, ургамалжилтад нөлөөлөл үзүүлэх, бохирдуулах	Зайлшгүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
2	Осол аваарын үед техникийн гаралтай бохирдуулагч хөрсөнд нэвчиж, ургамалжилтад нөлөөлөл үзүүлэх, бохирдуулах	Зайлшгүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
НИЙТ			2	-	-	-	-
ЭЗЛЭХ ХУВЬ (%)			100	-	-	-	-
	ДҮГНЭЛТ	Химийн бодисын агуулах болон бодисын хадгалалт, тээвэрлэлт, ашиглалтаас ургамлан бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл 100 % маш бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд тохиолдох магадлал нь ховор байна. Химийн бодисуудын тээвэрлэлт, хадгалалтаас үүсэх болзошгүй нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажилласан тохиолдолд ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл бага юм.					

3.5. Хүний эрүүл мэндэд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ

Химийн бодисын агуулахад хүний эрүүл мэндэд эрсдэл үүсгэж болзошгүй эх үүсвэр нь нэр бүхий 2 төрлийн бодис, бүтээгдэхүүн бөгөөд аюулгүй ажиллагааг хангаж ажиллаагүй нөхцөлд химийн бодисууд нь эрсдэл үүсгэх шууд эх үүсвэр болно.

Химийн бодисыг тээвэрлэх, хадгалах үйл ажиллагааны явцад эрсдэл үүсэх эсэх нь тухайн химийн бодистой харьцан ажиллаж буй хүнээс шууд хамааралтай байдаг. Өөрөөр хэлбэл агуулахад ажиллаж 7 хүний хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг ханган ажиллахаас үүсэж болзошгүй эрсдэл нь шууд хамааралтай юм.

Нөгөө талаар эрсдэлийн шинж чанар, цар хүрээнээс хамааран агуулахын ажилчид болон Баянгол сумын оршин суугчид эрсдэлд өртөгч болно. Ялангуяа химийн бодисуудтай харьцан ажиллах 7 ажилтан илүүтэйгээр өртөж болзошгүй юм.

Аливаа химийн бодисын бохирдол эх үүсвэрээс хөрс, ус, агаарт алдагдаж тухайн орчны ургамал, амьтныг хордуулахаас гадна хүнсний бүтээгдэхүүнд шингэж, хуримтлагдаж тухайн бохирдсон хөрс, ус, агаараар амьсгалах, хүрэлцэх, мөн бохирдсон хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэх зэрэг замуудаар хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг. Химийн бодисын бохирдлын

хүний эрүүл мэндэд нөлөөлөх нь бодисын тун хэмжээ, тухайн бодисын шинж чанар, био задралд орох чадвар, хуримтлагдах чадвар зэрэг хүчин зүйлсээс хамаардаг.

Өөрөөр хэлбэл нэр бүхий 2 төрлийн химийн бодис, бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалтыг буруу явуулсан тохиолдолд хортой бодисууд тул аюулгүйн дүрмийг сайтар баримталж ажиллахгүй бол ажиллагсдын эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй. Иймд химийн бодистой харьцаж ажиллах ажилтнууд нь энэ чиглэлийн мэргэжлийн хүн байх заавал шаардлагатай.

Харин химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтын явцад хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй нөлөөллийг нэгтгэн авч үзье. Үүнд:

1.Химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдлоос үүдэн аюул, осол гарах.

2.Мэргэжилтэн, ажилтны чадваргүй байдал, хариуцлагагүй үйлдэл, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллаагүйгээс ажлын байранд химийн бодис алдагдах, хүний эрүүл мэндэд нөлөөлөх.

3.Үйлдвэрлэгчээс гаргасан хор аюулын лавлах мэдээллийг үндэслэн химийн бодис, бүтээгдэхүүн эсвэл химийн бодис хадгалах үйл ажиллагааг нэг бүрээр боловсруулж мөрдөөгүйгээс аюулгүй байдал алдагдах, хүний эрүүл мэндэд нөлөөлөх.

4.Химийн бодисыг хамт хадгалж болохгүй бодис болон зориулалтын бус орчин, агуулахад хадгалснаас хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэх.

5.Химийн бодисыг хадгалах үйл ажиллагаа нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байр, талбай, ослын үед ажиллах арга хэмжээний төлөвлөгөөгүй ажилласнаас хүний эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд хохирол үүсэх.

6.Химийн бодистой харьцаж ажиллах ажиллагсад нь зохих шатны сургалтад хамрагдаагүй, зохих мэдлэг дадлыг эзэмшээгүйгээс химийн бодистой харьцаж ажиллах хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг зөрчих, хордох.

7.Химийн бодисын агуулахад хор аюулын лавлах мэдээлэлд заасан болзошгүй аюул, ослын үед ашиглах багаж хэрэгсэл, материалыг ажлын байранд байршуулж, ажиллагсдад ажиллах дадлыг эзэмшүүлээгүйгээс хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учрах.

8.Бодис нь хэвийн нөхцөлд тогтвортой боловч өндөр температурт шатах, хүчтэй хүчлүүдтэй урвалд орвол аюултай бодис тул харьцах үедээ хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллаагүйгээс асгарч алдагдах, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөл үзүүлэх зэрэг болно.

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Майнс Ап” ХХК нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 Дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар шинэчлэн баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу Химийн бодисын агуулах төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө гэж Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.8-д заасан төлөвлөгөөг ойлгоно. Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагын хянаж баталсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн байгаль орчны үндсэн баримт бичиг болно.

“Майнс Ап” ХХК -ийн Химийн бодисын агуулах төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний байгаль хамгаалах төлөвлөгөөнд шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгалаа.

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд Химийн бодисын агуулахын ажиллагсад бодистой ажиллах болон асгарсан бодисыг саармагжуулах, хурааж авах зэрэг ажиллагааны явцад хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэлгүй ажиллах зэрэг тохиолдолд бодист түлэгдэх, бодисын уураар амьсгалах, хордох зэрэг эрсдэл үүсэж болзошгүй тул хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны их бүрэн хамгаалах хэрэгслээр хангах, Химийн бодис асгарах, алдагдах үед ашиглах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хоосон сав, бортого, бортого онгойлгогч, наалддаг шошго, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэрэг багаж хэрэгслээр хангагдсан байх зэрэг арга хэмжээг төлөвлөхөө.

Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах багасгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал, мян.төг (1 жилийн)	Хэрэгжү үлэх хугацаа	Баримтлах хууль, журам, стандарт
1	Химийн бодисын агуулахад химийн бодистой харьцан ажиллах үед санамсаргүй асгах, алдах, агуулахын шал, гадаад орчинд асгарснаас ажлын байрны орчны агаарт нөлөөлөх	Химийн бодисын агуулахын ажиллагсад бодистой ажиллах болон асгарсан бодисыг саармагжуулах, хурааж авах зэрэг ажиллагааны явцад хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэлгүй ажиллах зэрэг тохиолдолд бодист түлэгдэх, бодисын уураар амьсгалах, хордох зэрэг эрсдэл үүсэж болзошгүй тул хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны их бүрэн хамгаалах хэрэгслээр хангах	Агуулах болон үйлдвэрийн барилга	2000.0	6-12 сар	Химийн бодис тус бүрийн хор аюулын лавлах мэдээлэл /MSDS/-ийг ашиглах
2	Хөрсөнд их хэмжээний химийн бодис алдагдсанаар ургамалжилт, хөрсний бичил биетэнд дам нөлөөлөл үзүүлэх	Химийн бодисын агуулахын ажлын байр нь тухайн бодисын хор аюулын лавлах мэдээлэлд заасан шингээгч материалаар (зориулалтын шингээгч, хуурай элс, тогтворжуулагч, үртэс гэх мэт) хангагдсан байна. Химийн бодис асгарах, алдагдах үед ашиглах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хоосон сав, бортого, бортого онгойлгогч, наалддаг шошго, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэрэг багаж хэрэгслээр	Агуулах	500.0	6-12 сар	Хөрсний дээж авах ерөнхий шаардлага MNS 6458:2014, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах.

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах багасгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал, мян.төг (1 жилийн)	Хэрэгжү үлэх хугацаа	Баримтлах хууль, журам, стандарт
		хангагдсан байх				Ерөнхий шаардлага Агуулахын барилга. БНБД 31-19-10, 2010
3	Химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдлоос үүдэн газрын гадаргад химийн бодис алдагдах, улмаар түүний урсцаар тархаж, голдирлын дагуух усыг бохирдуулах	Химийн бодисын агуулахын барилга байгууламж нь шалыг химийн үйлчлэлд тэсвэртэй зузаан материалаар хийсэн боловч нэвчилт, алдагдлыг байнга шалгаж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч байх	Агуулахад болон үйлдвэр	Урьдчилан тооцох боломжгүй	6-12 сар	Химийн бодис тус бүрийн хор аюулын лавлах мэдээлэл /MSDS/-ийг ашиглах
4	Мэргэжилтэн, ажилтны чадваргүй байдал, хариуцлагагүй үйлдэл, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллаагүйгээс ажлын байранд химийн бодис алдагдах, хүний эрүүл мэндэд нөлөөлөх	Химийн бодисын агуулахад ажиллаж буй мэргэжилтэн нь хор аюулын лавлах мэдээлэлд заасан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллахаас гадна химийн бодис алдагдахаас урьдчилан сэргийлсэн бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх, асгарч алдагдсан тохиолдолд түүнийг саармагжуулах арга хэмжээг авах чадварыг эзэмшсэн байх, мэргэжлийн сургалтад хамрагдах	Агуулах болон үйлдвэрийн ажилчид,	1000.0	6-12 сар	MNS 5002:2000 Ажлын байрны эрүүл ахуй ба хөдөлмөр хамгаалал. Дуу чимээний нормд тавигдах ерөнхий шаардлага ба аюулгүй ажиллах аргачлал MNS 5003:2000 Ажлын байрны эрүүл ахуй ба хөдөлмөр хамгаалал. Дуу

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах багасгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал, мян.төг (1 жилийн)	Хэрэгжү үлэх хугацаа	Баримтлах хууль, журам, стандарт
						чимээ хэмжих ерөнхий шаардлага
5	Үйлдвэрлэгчээс гаргасан хор аюулын лавлах мэдээллийг үндэслэн химийн бодис, бүтээгдэхүүн эсвэл химийн бодис хадгалах үйл ажиллагааг нэг бүрээр боловсруулж мөрдөөгүйгээс аюулгүй байдал алдагдах, хүний эрүүл мэндэд нөлөөлөх	Аюулгүй ажиллагааны зааварчилгааг өөрийн байгууллагын даргаар батлуулан ажлын байр болон агуулахад химийн бодистой харьцаж ажилладаг ажилтан өдөр тутмын ажиллагаанд ашиглаж байх боломжтой харагдахуйц газарт байрлуулах бөгөөд аюулгүй ажиллагааны зааварчилгаанд химийн бодисын хор аюул, үүсэж болох эрсдэл /хүний эрүүл мэнд, байгаль орчин/, химийн бодистой харьцах, хадгалах зааварчилгаа, асгарч алдагдсан болон галын аюулын үед авах арга хэмжээ, анхны тусламж, хувийн хамгаалах хэрэгсэл, хэрэглэх заавар, хаягдлыг устгах зааварчилгааг зэргийг багтаасан байна.	Агуулах болон үйлдвэрийн барилга дотор	500.0	6-12 сар	MNS 6458:2014, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах.
6	Химийн бодистой харьцаж ажиллах ажиллагсад нь зохих шатны сургалтад хамрагдаагүй, зохих мэдлэг дадлыг эзэмшээгүйгээс химийн бодистой харьцаж ажиллах хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг зөрчих, хордох	Химийн бодистой харьцаж ажилладаг ажиллагсдыг үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг хянах, эрсдэл үүссэн тохиолдолд хариу арга хэмжээ авах мэдлэг, дадлыг эзэмшүүлэх сургалтад заавал хамруулсан байх Хэрэв алдагдсан тохиолдолд дүүргийн Онцгой байдлын газарт хандаж саармагжуулах арга хэмжээг авах шаардлагатай.	Агуулах болон үйлдвэрийн ажилчид,	500.0	6-12 сар	MNS 6458:2014, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах.

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах багасгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал, мян.төг (1 жилийн)	Хэрэгжү үлэх хугацаа	Баримтлах хууль, журам, стандарт
7	Химийн бодисын агуулахад хор аюулын лавлах мэдээлэлд заасан болзошгүй аюул, ослын үед ашиглах багаж хэрэгсэл, материалыг ажлын байранд байршуулж, ажиллагсдад ашиглах дадлыг эзэмшүүлээгүйгээс хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учрах	Химийн бодисын агуулахын болзошгүй аюул, ослын үед ашиглах, хор аюулын лавлах мэдээлэлд заасны дагуу бүрэн ажиллагаатай гал унтраах багаж, хэрэгсэл, хор саармагжуулах бодис,уусмал, химийн бодис асгарч алдагдсан үед ашиглах багаж, хэрэгсэл, шингээгч материал, хувийн хамгаалах хэрэгсэл (арьс, нүд, амьсгал хамгаалах), амьсгал хамгаалах баг,шаардлагатай тохиолдолд нүд угаах болон ослын шүршүүр зэргийг ажлын байранд байршуулж, ажиллагсдад ажиллах дадлыг эзэмшүүлэх	Агуулах болон үйлдвэрт	1500.0	6-12 сар 6-12 сар	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
	Нийт			6000.0		

БҮЛЭГ 6. ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд 1000 ш мод тарихаар төлөвлөлөө.

Хүснэгт 10. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Материалын нэр		Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ, төг	1 жилийн Нийт үнэ, мян.төг	Тайлбар
1	Хайлаас, улиас, нарс, гацуур мод	ш	1000	1.0	1000.0	Дүүргийн болон ойн газраас санал болгосон газарт тарина. 10 сарын эхний 7 хоногт
Нийт					1000.0	

БҮЛЭГ 7. ОРЧНЫ ТОХИЖИЛТ НОГООН БАЙГУУЛАМЖИЙН АРГА ХЭМЖЭЭ

Нийт тохижуулах талбайн хэмжээ ~2300м² талбайг хамарна.

Гадна тохижуулах талбай



Нийт тохижуулах талбайн
хэмжээ
~2300м²

Хийгдэх ажлын дараалал

- Үндэс болон хөвөнгөөр ургасан улиасыг сугалах
- Модны мөчрийг тайрж хэлбэржүүлэх
- Сугалсан болон тайрсан мод бутыг ачиж устгалд оруулах
- Эскаватор ашиглан хөрсийг 30 см ухаж тэгшилнэ
- Шинээр хар шороон хөрс болон элс авчирж зүлэгжүүлэх талбайн бэлтгэл ажлыг хангана
- Шинэ хөрс дэвсэж бордох- (Дотороосоо хүн хүч бэлдэх)
- Зүлэг тарилтын өмнөх усалгаа (Дотороосоо хүн хүч бэлдэх)
- Зүлэгний үр цацах (Дотороосоо хүн хүч бэлдэх)
- Шилмүүст мод, бут суулгах (Дотороосоо хүн хүч бэлдэх)
- Өдөр тутмын усалгаа
- Зэрлэг өвс шарилж устгал (Дотороосоо хүн хүч бэлдэх)
- Гадна тохижилтыг сайжруулах (Дотороосоо хүн хүч бэлдэх)
- Зүлэгний үр цацсаны дараах ус чийг болон шувуунаас хамгаалах элсэн давхарга дэвсэлт

Хүснэгт 11. Ногоон байгууламж төлөвлөлтийн зардал

	Нэгж	Хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
Хар хөрс	м2	2300	500'000	500'000
Элс	м2	2300	100'000	100'000
Бордоо	кг	30	40'000	120'000
Зүлэгний үр	кг	4	35000	140'000
тармуур хүрз шигшүүр модны хайч)	ш	20	30000	1140'000
Нийт				2000'000

БҮЛЭГ 7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайд дахиж шинээр барилга байгууламж баригдахгүй тул түүх соёлын арга хэмжээг төлөвлөөгүй болно.

БҮЛЭГ 8. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Майнс Ап” ХХК-ийн Химийн бодисын агуулах төслийн үйл ажиллагааны явцад ажилчдын аюулгүй байх орчин нөхцөлийг ханган хөдөлмөр хамгаалал, осол аюулгүйн талаарх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Хүснэгт 12. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах багасгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах хууль, журам, стандарт
1	Гэнэтийн осол эрсдэлээс сэргийлэх	Гал түймрийн үед хэрхэн ажиллах талаар ажилчдын дунд сургалт явуулах	Агуулах болон үйлдвэр	250.0	9 сард	
2	Аюулгүй ажиллагааны тэмдэглэгээ	Ажлын байранд гал гаргахыг хатуу хориглосон анхааруулга тэмдгийг үзэгдэхүйц газар байрлуулах	Агуулах, үйлдвэрт	250.0	6-9 сард	MNS 6458 : 2014 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага С хавсралт
3	Болзошгүй осол аваар гарах, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчсөнөөс аюул осолд өртөх;	Нэг бүрийг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр (ажлын хувцас, өвөл, зуны гутал, хамгаалалтай нүдний шил, бээлий, чих бөглөгч г.м) хангах	Ажилчид	-	6 сард	MNS 4968:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. эрүүл ахуй. Ерөнхий шаардлага

Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах
 “Майнс Ап” ХХК-ийн “Химийн бодисын агуулах” төслийн 2026 оны
 байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2026 он

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах багасгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах хууль, журам, стандарт
4	Гэнэтийн осол эрсдэлээс сэргийлэх	Ажилчдад ослын үед цаг алдалгүй анхны тусламж үзүүлэх зорилготой анхны тусламж үзүүлэх эмийн сан байрлуулсан байна.	Агуулах, үйлдвэрт	500.0	6-12 сард	MNS4990:2015 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй, Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага
	Нийт			1000.0		

БҮЛЭГ 9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Майнс Ад ХХК нь Хог хаягдлын тухай /шинэчилсэн найруулга/ хуульд заасан хог хаягдлын талаар аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүргийг биелүүлэн ажиллах шаардлагатай.

Хүснэгт 13. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Төсөл хэрэгжүүлэгчийн бүтээгдэхүүн борлуулах цэг болон гэрээлэгч байгууллагуудад, хэрэглэгчдэд борлуулсан бүтээгдэхүүн, тэдгээрийн сав баглаа боодлыг эргүүлэн татан авах	Хэрэглэгчид худалдаалах нэр бүхий 14 төрлийн бүтээгдэхүүнээс жилд дунджаар 1 тн-ын багтаамжтай ИВС хуванцар сав 920 ш, 400 гр багтаамжтай жижиг хуванцар сав 60000 ш тус тус хаягдал болон гарах ба тэдгээрийн хаягдал савыг эргүүлэн татан авч агуулахад түр хадгалах. Ялангуяа гэрээлэгч байгууллагад нийлүүлэхдээ худалдаалсан бүтээгдэхүүний савыг эргүүлэн татан авах талаар гэрээ байгуулан ажиллах.	2000.0	6-12 сар	Хог хаягдлын тухай хууль
2	Бүтээгдэхүүнээс гарсан 1 тн-ын багтаамжтай ИВС хуванцар сав, 400 гр багтаамжтай жижиг хуванцар сав буюу аюултай хог хаягдлыг тээвэрлэх	Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг БОАЖЯ-аас эрх авсан тусгай зөвшөөрөл бүхий Мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан хуваарийн дагуу тээвэрлэн татаж авах	1500.0	6-12 сар	

Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах
 “Майнс Ап” ХХК-ийн “Химийн бодисын агуулах” төслийн 2026 оны
 байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2026 он

3	Аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр түр хадгалах	Аюултай хог хаягдлыг үүсгэгч буюу төсөл хэрэгжүүлэгч нь Хог хаягдлын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан шаардлагыг биелүүлэн ажиллах	1000.0	6-12 сар	
4	Бүтээгдэхүүний сав баглаа боодлын хаягдлыг цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч байгууллагад нийлүүлэх	Аюултай хог хаягдлыг цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагааг БОАЖЯ-аас эрх авсан тусгай зөвшөөрөл бүхий Мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан ажиллах	2500.0	6-12 сар	
	Нийт		7000.0		

БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг **“Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр”** гэнэ. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тухайн төслөөс байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг /ус, хөрс, ургамал гэх мэт/ тус бүрд гарах бохирдол, аливаа өөрчлөлтийг хянах шинжилгээний арга аргачлал, хяналт шинжилгээ хийх хугацаа, сорьц авах болох хэмжилт хийх цэгийн байршил, баримтлах стандартууд зэргийг тодорхойлно.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, байгаль хамгаалах төлөвлөгөөг улам боловсронгуй болгох, байгаль орчноо хамгаалах, орон нутгийн захиргаа, хяналтын болон нутгийн оршин суугчдад бодитой мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой. ОХШХ нь БОХТ-тэйгээ нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө. Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, тэдгээрт хэмжилт, дээжлэлт хийх шинжилгээний аргууд, хяналтын цэгийн байршил, хяналт хийх хугацаа ба давтамж зэргийг ажлын хэмжээг хэмжих нэгж, нэгжийн үнэ, нийт зардал, баримтлах стандарт, аргазүй, аргачлалын хамт тусгаж боловсруулан оруулна. Химийн бодисын агуулахын талбайн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчмийг харгалзан үзэж, төслийн талбай болон түүний орчны бүсийн талбайг хамран байгаль орчны хяналт шинжилгээг жил бүр тогтмол хийж байх хэрэгтэй.

Хүснэгт 14. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Бүрэлдэхүүн	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал төг/жил	Баримтлах стандарт ба арга аргачлал
Агаарын чанар	Хүхрийн исэл SO2 Нүүрстөрөгчийн дутуу исэл CO Азотын исэл NOx Тоос	Ажлын байрны гадна дотор	8 болон 10 сард 2 цэгээс	800.0	1300.0 мян.төг	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 3383:1982 Агаар мандал. Бохирдлын эх үүсвэр, нөхцөл байдал ба тодорхойлолт MNS 4990:2000. Ажлын байрны эрүүл ахуй ба хөдөлмөр хамгаалал. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 5885:2008 Агаар бохирдуулагч бодисуудын хүлээн зөвшөөрөгдсөн концентрац. Техникийн ерөнхий шаардлага MNS (ISO) 4225:2001 Агаарын чанар. Ерөнхий танилцуулга
	Ажлын байрны дотоод агаарын чанар			500.0		
Хөрсөн бүрхэвч	pH, ялзмагийн агууламж, ялзмагт давхаргын зузаан, механик бүтэц, нийт азот, нийт фосфор, хүнд металлууд, 1 см3 дэхь бактери, эмгэг төрүүлэгч бичил биетэн байгаа эсэх	Агуулахын хашаан доторх хог хаягдлын цэг, хэрэв бохирдол үүссэн бол түүний орчимд	8 болон 10 сард 2 цэгээс	700.0		MNS 3298:1991 Хөрс. Хөрсний дээж авах ерөнхий шаардлага

Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах
 “Майнс Ап” ХХК-ийн “Химийн бодисын агуулах” төслийн 2026 оны
 байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2026 он

Агуулах	Төслийн үе шатанд хэрэглэгдэж буй бодисын хадгалалт, тээвэрлэлтийн үеийн бүрэн бүтэн байдал, шүүрэл асгаралтын байдал, хадгалах орчны горим, параметруудад үзлэг шалгалт хийх	Химийн бодисын агуулах	6-12 сар	Цалингийн сард	MNS 6458:2014, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага. Барилга, байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм. БНБД 21-02 -02 Агуулахын барилга. БНБД 31-19-10, 2010
	Нийт			2000.0	

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ, ДҮГНЭЛТ

“Майнс Ап” ХХК-ийн Химийн бодисын агуулах төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг тодорхойлон нэгтгэж тусгав.

Химийн бодисын агуулах төслийн 2026 оны БОМТ-г Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 дугаар тоот тушаалаар баталсан аргачлалыг баримтлан боловсруулсан болно. БОМТ-нд 1 жилд **18 000 000** төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.

Хүснэгт 15. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт

№	Зардлын утга	Нийт зардал, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	7 000 000
2	Тэрбум мод хөтөлбөр	1 000 000
3	Орчны тохижилд ногоон байгууламжийн төлөвлөлт	2 000 000
4	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1 000 000
	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	5 000 000
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2 000 000
	2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн	18 000 000

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт **18 000 000** төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна. БГД-ийн байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа 9000 000 төгрөгийг 100200355301 дансанд байршууллаа.